


Жамбын ДАШАНДОГ

Эрээн Халчуурт



Ж.Дашдондог
ЭРЭЭН АЛЧУУРТ

Сургуулийн бага, дунд насныханд зориулав.

Зураач Н.Хүдэрчулуун

Хянан тохиолдуулагч О.Мөнхтуяа
Хэвлэлийн эх бэлтгэсэн Д.Хишигдалгэр



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он



Ээж нь хот ороод ирэхдээ хайртай охиндоо цэцгэн хээтэй эрээн алчуур авчирч өгчээ. Охин нь түүнийг орсон ч, гарсан ч зангидна. Бас хаа ч явсан “Эхийн ач” дуу аялж, ээжийнхээ ачийг хариулна даа гэж ярьдаг. Харин яаж хариулахаа сайн мэдэхгүй байлаа.



Нэгэн удаа түүнд айлынх нь хүн, шүүдрийн дусал түүж ээждээ цай чанаж өгвөл ачийг нь хариулж болох тухай ярьжээ.



Эрээн алчуурт өглөө эрт босч хувин тохойвчлоод
цэцэгт хөндий зорив гэнэ. Наран сөрөг харвал түм
буман мөнгөн шүүдэр! Ямар гоё вэ? Шүүдрийн ургац
ийм их байхад хувин дүүргэх юухан байхав. Бушуухан
түүж ээждээ цай чанаж өгөхсөн гэж тэр яарна.



Гэвч жимс түүхээс ч хэцүү ажээ. Түүж түүж харахад савны ёроол хэвээрээ. Тэгэхээр эхийн ачийг хариулна гэдэг тийм ч амар юм биш байх нь.




Эрээн алчуурт маань түүсээр түүсээр нэг мэдэхэд унтаж орхижээ. Хэрэв зөгий алчуурыг нь цэцэг гэж андуурч буугаагүй бол хэдий болтол унтах байсныг бүү мэд.



Ёо! гээд цочин сэрлээ. Шүүдрээ түүх гэтэл ганц дусал ч алга. Хэн уучихав. Нар дээшилжээ. Анивчиж шоолоод ч байх шиг. Тэр л ууснаас зайлахгүй.



Эрээн алчуурт уйллаа. Ээжийнхээ ачийг хариулж чадахгүй нь гэж бодохоос л нулимс нь аяндаа шүүдрийн дусал шиг бөмбөрч байлаа.



Яая гэхэв, хоосон савтайгаа гэрийн зүг эргэтэл гэнэт нэг чоно зогсож байв. Эрээн алчуурт “Ээж ээ!” гээд хашгиран зугатлаа.



Цайгаа чанаж суусан эхийн чихэнд охиных нь дуу сонсдож, нүдэнд нь өлөн чоно үзэгдэх шиг болоход галын хайчаараа дохин "Жов!" гэлээ.



Тэр агшинд эрээн алчуурт руу дайрсан чоно гэнэт зог тусан эргэж цэцэгт талын дундуур бараа сураггүй алга болов.



Ээж нь гэнэт охиноо үгүйлэн гэрээс гүйж гарлаа. Тал руу саравчлан хартал цэцэгнээс үл ялгарам эрзэн алчуурт охин нь “Ээж ээ!” гэсээр айсуй.



Ээж охин хоёр тэврэлдэн уулзлаа. Болсон явдлын тухай нэгд нэггүй ярихад ээж нь "Тийм байх аа! Даанч нүдэнд чоно үзэгдэх шиг болсон юм" гэв. "Эвий бяцхан үр минь ээждээ хүрээд ирсэн хойно шүүдрийн дуслаар чанасан цайг чинь ууснаас ялгаагүй" гээд ээж нь эрзэн алчуурт охиноо удаан үнсэх нь тэр бөлгөө.



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.